



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/21

Сүхбаатар

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,  
сунгах тухай

Монгол Улсын аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1,12.1,15.12.4, 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хушаат, Цагааннуур, Түшиг, Ерөө, Сант, Алтанбулаг, Орхонтуул, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Баянгол, Хүдэр сум, Мандал сумын Түнхэл, Хэрх тосгон, Ерөө сумын Бугант тосгон, Шаамар сумын Дулаанхан тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн, Сайхан сумын сум дундын эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар, Сүхбаатар сумын “Өөжиг дент”, Мандал сумын “Инээмсэглэл” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.

2.Мандал сумын “Хишиг ДБ”, Бугант тосгоны “Өлгий Ерөө” эмийн сан, Сүхбаатар сумын “Монос” эм ханган нийлүүлэх байгууллагад тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар тус тус олгосугай.

3.Тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ

